

НИЙСЛЭЛИЙН ТӨРИЙН ӨМЧИЙН ЦЭЦЭРЛЭГТ

“ЦАХИМ БҮРТГЭЛ, ЭЛСЭЛТ”-ИЙГЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОХ САНАМЖ

I. ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА, МЭРГЭЖИЛТЭНД

1. “ЦАХИМ БҮРТГЭЛ”-ийн явцад ОӨУБГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу шинээр нэмэгдсэн гудамж,байрыг хамран сургах тойрогт хамааруулах ажлыг тухай бүрд нь зохион байгуулах
2. Шинээр нэмэгдсэн гудамж, байрыг Нийслэлийн Боловсролын газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/40 дүгээр тушаалын (“Цэцэрлэгийн хамран сургах тойрог тогтоох тухай”)хавсралтад тусгагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хамран сургах тойрогт давхар тусгаж 2017 оны 08 дугаар сарын 24-ний 14.00 цагт bolormaa@edub.edu.mn хаягаар ирүүлэх
3. “ЦАХИМ БҮРТГЭЛ”-ийн явцын талаарх мэдээллийг дараах агуулгын хүрээнд зохих өдрүүдэд хариуцсан ажилтнаар дахин гаргуулж “Цахим тасалбар” үйл ажиллагааг зохион байгуулах цэцэрлэгүүдийг тодорхойлж нэгтгээд судалгааг ажлын цагт багтаан bolormaa@edub.edu.mn хаягаар ирүүлэх

..... дүүрэг

№	Цэцэрлэгийн дугаар	Хяналтын тоо	Бүртгүүлсэн хүүхдийн тоо		“Цахим элсэлт” зохион байгуулах эсэх	Тайлбар
			2017.08.21.	2017.08.24.		
Нийт дүн						

4. 2012-2014 онд төрсөн хүүхдийг шинээр элсүүлэх цэцэрлэгүүдэд бүртгүүлэгчдийн тоо хяналтын тооноос давсан тохиолдолд “Элсэлтийн тасалбар” үйл ажиллагааг зохион байгуулах эсэх асуудлыг орон нутгийн түвшинд шийдвэрлэн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллан дараах агуулгын хүрээнд мэдээллийг нэгтгэн тайлбар, дүгнэлттэйгээр 2017.08.24-ний өдрийн 16.00 цагт ирүүлэх

..... дүүрэг

№	Цэцэрлэгийн дугаар	3 нас		4 нас		5 нас		“Элсэлтийн тасалбар” зохион байгуулах эсэх(аль нэг бүлэгт эсвэл бүх бүлэгт)
		Хяналтын тоо	Бүртгүүлсэн хүүхдийн тоо	Хяналтын тоо	Бүртгүүлсэн хүүхдийн тоо	Хяналтын тоо	Бүртгүүлсэн хүүхдийн тоо	
Нийт дүн								

5. “Элсэлтийн тасалбар” үйл ажиллагааг зохион байгуулах цэцэрлэгүүдийг холбогдох заавраар ханган үр дүнг тооцон ажиллах

6. 2017.08.25-ны өдрийн 10.00 цагт цэцэрлэгүүдэд “ЦАХИМ ЭЛСЭЛТ”-ийг зохион байгуулах бөгөөд “ЭЛСЭЛТИЙН ТАСАЛБАР”-ын үйл ажиллагааны хугацааг зэрэгцүүлэлгүйгээр орон нутгийн түвшинд тогтоох
7. Цэцэрлэгийн эрхлэгчид элсэлтийн цахим бүртгэлийн програмд нэвтрэн орох эрхээ нээлгэсэн эсэх, нэвтрэн орсон тохиолдолд нууц үгээ сольсон эсэхэд хяналт тавьж ажиллах
8. “ЦАХИМ ЭЛСЭЛТ”, “ЭЛСЭЛТИЙН ТАСАЛБАР” зохион байгуулах цэцэрлэгүүдийг мэргэжлийн удирдлагаар ханган гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллах
9. Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлт бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан ажлын тайланг 2017.08.26-ны 11.00 цагт багтаан НБГ-т ирүүлэх

II. ТӨРИЙН ӨМЧИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ НАРТ

1. Цэцэрлэгийнхүүхдийн элсэлтийг зохион байгуулах комиссыг эрхлэгчийн тушаал аарбагш, ажилтан, эцэг, эхийн төлөөлөл¹, хорооны ажилтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хяналт тавьж ажиллах
2. “ЦАХИМ ЭЛСЭЛТ”, “ЭЛСЭЛТИЙН ТАСАЛБАР” зохион байгуулах байр, талбайг холбогдох техник хэрэгсэл, шаардлагатай бусад материалын хамт бэлтгэж өргөн хүрээтэй төлөөлөл оролцуулах арга хэмжээ авч ажиллах
3. Цэцэрлэгийн эрхлэгчид элсэлтийн цахим бүртгэлийн програмд нэвтрэн орох эрхээ нээлгэх (Утасны дугаар +123456), нэвтрэн орсон тохиолдолд нууц үгээ заавал сольсон байхад анхаарах
4. Програмд нэвтрэн орох “Нууц үг”-ийн нууцлалыг чанд хадгалан ажиллах, гарах сөрөг үр дүнгээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах
5. Үйл ажиллагааны нээлттэй байдлыг ханган ажиллах
6. Цэцэрлэгийн элсэлт бүртгэлтэй холбоотой судалгаа, мэдээллийг зохих хугацаанд, үнэн зөв, тодорхой гаргаж тайлагнах

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР

¹Монгол Улсын хууль Сургуулийн өмнөх боловсролын тухай 14.1.4